

**2016 ОНД ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГАД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

д/д	он, сар, өдөр	Удирдамжийн дугаар	Тэргүү /хаана/	Товч танилцуулга
1.	2016.01.20	38-07-068/01	Төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай /УБТЗ ХНН-ийн Дархан өртөө, Дархан гурил тэжээл ХХК/	“Дархан таван нуур” ХХК-ийн 1/145 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу ТНБД-ын даргын баталсан 038/07/68/01 дугаар удирдамжийн дагуу “УБТЗ” ХНН-ийн Дархан өртөөнд газар дээр нь ажиллаж салбар төмөр замд вагоноос буудай буулгах бункерын барилгын ажлыг шалгаж 16/01/01 дугаар техникийн хамтарсан дүгнэлт гаргасан.
2.	2016.02.17	38-07-068/02	Салбар төмөр замын өргөтгөлийн техникийн нөхцөл судлах тухай/Дархан таван нуур ХХК/	“Дархан таван нуур” ХХК-ийн 2016.01.22-ны 0/05 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу ХШҮДАГ-ын даргын баталсан 038/07/68/02 дугаар удирдамжийн дагуу “УБТЗ” ХНН-ийн Дархан өртөөнд газар дээр нь ажиллаж салбар төмөр замд вагоноос буудай буулгах бункерын барилгын ажил болон салбар төмөр замыг өргөтгөх боломжийг шалгаж техникийн 16/01/02 дугаар хамтарсан дүгнэлт гаргасан.
3.	2016.02.23	38-07-078/03	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай/УБТЗ ХНН-ийн Улаанбаатар дахь суудлын вагон, 263 дугаар галт тэрэг/	Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан 38-07-078/03 дугаартай удирдамжаар “УБТЗ” ХНН-ийн Улаанбаатар дахь Вагон депо /ВЧД-2/, Орон нутгийн галт тэрэгний техникийн болон үйлчилгээний чанарын байдал, “Зорчигчийн 1012 дугаар вагонд утаа гарсан гомдол”-ын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2016.02.22-23-ний хооронд хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтыг Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ЗТХХ-ийн төмөр замын тээврийн хяналтын ахлах мэргэжилтэн, Улсын байцаагч М.Энхболд, мэргэжилтэн, Улсын байцаагч Б.Очхүү нар Улаанбаатар дахь Вагон депогийн ашиглалт эрхэлсэн орлогч дарга Б.Юлхарсүрэн, ашиглалт хариуцсан инженер Э.Хүрэлхүү, галт тэрэгний дарга Б.Ганчимэг, вагоны үйлчлэгч Э.Уранчимэг, Д.Оюунчимэг, Р.Хишигсүрэн

				нарыг оролцуулан хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар галлагааны технологи алдсан бөгөөд хариуцлага алдсан галт тэрэгний дарга Б.Ганчимэг, вагоны үйлчлэгч нарт сахилгын арга хэмжээ авсан байна.
4.	2016.02.22	38-07-074/04	Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх тухай/Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр ХХК-ийн төмөр замын цех/	ХШУДАГ-ын даргын баталсан 2016.02.22-ны өдрийн 038/07/074/49 гүйцэтгэлийн хяналт шалгалтын удирдамжаар Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн төмөр замын цехэд 2016.02.25-ны өдөр хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. 2015 оны улсын байцаагчийн 038/07/074/49 албан шаардлагын биелэлт 67.5% буюу хангалтгүй байсан тул дахин улсын байцаагчийн 038/07/074/03 дугаартай хугацаатай албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгасан.
5.	2016.02.26	38-07-71/05	Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай /УБТЗ ХНН-ийн Дохиолол холбооны 2 анги/	ХШУДАГ-ын даргын баталсан 2016.02.26-ны өдрийн 038/07/071/05 дугаартай удирдамжийн дагуу УБТЗ ХНН-ийн Дохиолол холбооны 2-р анги болон УБ өртөө, Довын байгууламжид хяналт шалгалт хийж, 078/07/071/08 дугаартай албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын хариу 2016.06.08-ны өдөр ирсэн. Зөрчил хангалттай арилсан байна.
6.	2016.03.07	38-07-078/06	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай /482 вагон/	“УБТЗ” ХНН-ийн Төмөр замын тээврийн хөдөлгөөнд тэнцэх эсэхэд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн албан хүсэлтийн дагуу Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан 38-07-078/06 дугаартай удирдамжаар “УБТЗ” ХНН-ийн Улаанбаатар дахь Вагон депо (ВЧД-2)-ийн шинээр тоноглон бүтцийн өөрчлөлт хийж буй 482 дугаартай зорчигчийн вагонд төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийсэн. Зорчигчийн 482 дугаар вагонд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх тухай” 2016 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 38/07/070/09 дугаартай дүгнэлт гарсан.
7.	2016.03.10	38-07-068/07	Төмөр замын зурвас газарт шалгалт хийх тухай /Сээкл ХХК/	“УБТЗ” ХНН-ийн Улаанбаатар өртөөний хойд талд төмөр зам дээгүүр гарсан явган хүний гарцыг хааж хашаа барьсан асуудлыг судалж ажлын хэсгийн танилцуулга гаргасан. ТЗДТБХЗГ-ын Төмөр замын зурвас газар хариуцсан Мэргэжилтэн Т.Энхбаатар БГД-ын газрын албатай хамтран газрыг чөлөөлүүлэхээр ажиллаж байна.

8.	2016.03.16	38-07-074/09	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай/УБТЗ ХНН-ийн Замын-Үүд, Монголросцветмент, Багануур, Шарын гол зэрэг 9 ААН/	УБТЗ ХНН-ийн Хяналтын албаны хүсэлтээр ТНБД-ын 2016.03.16-ны өдөр баталсан 038/07/074/09 дугаартай удирдамжийн дагуу 2016.03.21-ээс эхлэн ажлын 10 хоногт УБТЗ ХНН-ийн Замын-Үүд өртөө дэх байгууллагууд, Бор-Өндөрийн УБҮ, Багануур ХК, Дулааны 4-р цахилгаан станц ТӨХК, Шарын гол ХК, Хөтөлийн Цемент шохой ХК, Эрдэнэт дулааны цахилгаан станц ТӨХК, Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн төмөр замын цех, хэсэгт төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтын мөрөөр 038/07/071/07-Шарын гол ХК, 038/07/068/09-Хөтөлийн Цемент шохой ХК, 038/07/068/10-Эрдэнэт дулааны цахилгаан станц ТӨХК, 038/07/071/11-Эрдэнэт үйлдвэр ХХК, 038/07/071/12-Багануур ХК, 038/07/071/13-Дулааны 4-р цахилгаан станц ТӨХК, 038/07/074/14-Бор-Өндөрийн УБҮ-т тус тус Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Бүх байгууллага албан шаардлагын хариу ирүүлсэн.
9.	2016.03.17	38-07-070/10	Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай /УБТЗ ХНН-ийн Замын-Үүд зангилаа/	Зам, тээврийн сайдын баталсан 2016.03.17-ны өдрийн 038/07/070/10 дугаартай удирдамжийн дагуу “УБТЗ” ХНН-ийн Замын-Үүд зангилаа болон холбогдох аж ахуйн нэгжид Зам, тээврийн яамны Зам, тээврийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга П.Билгүүн, Зам, тээврийн хяналтын хэлтсийн төмөр замын тээврийн хяналтын ахлах мэргэжилтэн, Улсын байцаагч М.Энхболд, төмөр замын тээврийн хяналтын мэргэжилтэн, Улсын байцаагч С.Майдар, Д.Батхүү, Б.Очхүү, Х.Итгэлт, төмөр замын тээврийн хяналтын мэргэжилтэн Т.Энхбаатар, Г.Даваадолгор, Б.Мөнхбаяр нар 2016.03.22-оос ажлын 3 хоног төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийсэн. Гүйцэтгэлийн шалгалт хийх шаардлагагүй.
10.	2016.04.15	38-07-068/12	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай /БТЕГ ХХК, МТЛ ХХК, Пик девелопмент ХХК/	“БТЕГ” ХХК-ийн 2016.02.22-ны 01/42 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу төмөр замын шугамтай авто зам огтлолцох зураг төслийг шалгаж хууль тогтоомжийн дагуу солбицол, түвшинг тодорхойлох техникийн нөхцөлийг өөрийн хариуцсан чиглэлээр шалгаж зураг төсөлд зөвлөмж

				өгсөн.
11.	2016.04.18	38-07-071/13	Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай /БТЕГ ХХК, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК, МТЗ ТӨХК/	Болд төмөр ерөө гол ХХК, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК, МТЗ ТӨХК-ийн хэмжээнд ачаа тээвэр, хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаад 038/07/071/13 дугаартай удирдамжийн дагуу 2016.04.26-ны өдрөөс 29-ний өдрийн хооронд шалгалт хийж, танилцуулж, 2016.05.19-ний өдөр 38/07/071/29 дугаартай 8 заалт бүхий албан шаардлага Болд төмөр ерөө гол ХХК-д хүргүүлсэн.
12.	2016.04.14	38-07-074/17	Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай /Баянтүмэн зангилаа/	Төрийн нарийн бичгийн баталсан 2016.04.04-ний өдрийн 038/07/074/017 удирдамжийн дагуу УБТЗ ХНН-ийн Баянтүмэн тасагт 2016.04.18-ны өдрөөс ажлын 4 хоногт хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтаар нийт 71 зөрчил илэрч, илэрсэн зөрчлийн дагуу Улсын байцаагчийн 038/07/074/019 дугаартай албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлагын хариу ирсэн бөгөөд зөрчлийг 87,6% хангалттай арилгасан байна.
13.	2016.05.03	38-07-070/18	Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай /УБТЗ ХНН-ийн ашиглалтын вагон депо/	Зам, тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдөр баталсан 038/07/070/18 дугаартай удирдамжийн дагуу “УБТЗ” ХНН-ийн “Вагон ашиглалтын депо”, түүний харьяа Улаанбаатар Вагон техник үзлэгийн газар /ТҮГ/, Толгойтын Вагон техник үзлэгийн газар, Улаанбаатар-2 ба Амгалан өртөөн дэх Улаанбаатар Вагон техник үзлэгийн газрын хэсэглэлүүдэд 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн ажлын 3 хоногт багтаан хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дагуу 2016.05.19-ний өдрийн Улсын байцаагчийн 038/07/070/28 дугаартай албан шаардлага хүргүүлсэн. “УБТЗ” ХНН-ийн “Вагон ашиглалтын депо”-гийн 2016 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 31/794 дугаартай албан бичгээр хариу ирүүлсэн. Улсын байцаагчийн албан шаардлагад заасан 4 заалтын 3-г нь биелүүлсэн ба 1 заалт “Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой гэрчилгээ”-г авах материалыг бүрдүүлэн ЗТХЯ-ны ТЗДТБХЗГазарт 2016 оны 06 дугаар сарын 07-ны 31/707 дугаартай “Гэрчилгээ хүсэх тухай” албан бичгээр хүргүүлсэн байна. ЗТХЯ-ны

				гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсэг холбогдох материалыг судлан үзээд дэмжсэн ба ЗТХ-ийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 97 дугаар тушаалаар гэрчилгээ олгохоор шийдвэрлэсэн байна.
14.	2016.05.11	38-07-068/19	Салбар төмөр замын барилгын ажлыг шалгах тухай /Юнайтед бест ойл ХХК, Толгойт өртөө/	“Юнайтед бест ойл” ХХК-ийн 2016.02.25-ны өдрийн 16/009 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу бүрдүүлсэн баримт бичгийг судалж “УБТЗ” ХНН-ийн Толгойт өртөөнд агуулахын зориулалттай салбар төмөр зам барьсан барилга угсралтын ажлыг шалгаж хамтарсан ажлын хэсгийн 16/019/04 дугаар дүгнэлт гаргасан
15.	2016.05.11	38-07-068/20	Салбар төмөр замын барилгын ажлыг шалгах тухай /Замын-үүд өртөө/	ТНБД-ын 2016.05.11-ны 38/07/068/20 дугаар удирдамжийн дагуу “УБТЗ” ХНН-ийн Замын-Үүд өртөөнд “Рэйлроуд инженеринг” ХХК-ийн барьсан ДЦС-ыг нүүрсээр хангах салбар төмөр замыг шалгаж ашиглалтад оруулах тухай ажлын хэсгийн нэгдсэн 16/020/05 дугаартай дүгнэлт гаргасан.
16.	2016.05.20	38-07-071/22	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай /МТЗ ТӨХК	Зам, тээврийн яамны <u>ТЗДТБХЗГ-аас</u> ирүүлсэн дотоод бичгийг үндэслэн <u>ХШУДАГ-ын даргын</u> 2016.05.20-ны өдөр баталсан 038/07/071/22 дугаартай удирдамжийн дагуу <u>Тавантолгой-Гашуунсухайт</u> чиглэлийн төмөр замын доод бүтцийн барилга угсралтын ажил байгалийн хүчин зүйл нөлөөнд автсан эсэх талаар хяналт шалгалт хийж, танилцуулж, 2016.05.19-ний өдрийн 38/07/071/15 дугаартай Улсын байцаагчийн дүгнэлт үйлдсэн.
17.	2016.05.24	38-07-070/23	Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай /Сонсголон бармат ХХК/	ЗТЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан 2016.05.24-ны 038/07/070/23 дугаартай удирдамжийн дагуу 2016.05.25-ны өдрөөс ажлын 2 хоногт багтаан “Сонсголон-Бармат” ХХК-ийн эзэмшлийн 25 думкар вагонд техникийн байдалд хяналт шалгалт хийсэн. Бүх вагонуудад 2015 онд депо засвар хийлгэсэн бөгөөд 2016 оны 05 дугаар сарын байдлаар тээвэрлэх ачаа байхгүй учир төмөр замын тээвэрлэлт оролцоогүй байна.
18.	2016.06.17	38-07-071/25	Төмөр замын зурвас газарт шалгалт хийх тухай /УБТЗ ХНН-ийн Авто бааз/	Удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийсэн. Авто баазын хашаа доторх талбайг түрээслэх эрх зүй байхгүй тул түрээслэх үйл ажиллагаагаа зогсоож, мэдэгдэх тухай албан

				бичгийг УБТЗ ХНН-т хүргүүлсэн.
19.	2016.06.13	38-07-071/26	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай /Өсөх урам ХХК/	Удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийсэн. Газрын даргад 2016.06.20-ны өдөр 071/26 дугаартай танилцуулга үйлдэж танилцуулсан. УБТЗ ХНН, Өсөх урам ХХК-д хяналт албан бичиг хүргүүлсэн.
20.	2016.07.23	38-07-068/27	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай /УБТЗ ХНН/	“УБТЗ” ХНН-ийн Дархан өртөөнд 6 вагон замаас гарсан ослыг судалж ажлын хэсгийн хамтарсан мэргэжлийн дүгнэлт гаргаж яамны удирдлагад танилцуулсан. /Ослын шалтгааныг замын аж ахуйн засварын ажлын дараа замын геометр хэмжээсийг дутуу шалгасан, ажлыг чанаргүй хийснээс болсон гэж дүгнээд 16/15 дугаар танилцуулга гаргаж яамны удирдлагад танилцуулсан.
21.	2016.08.24	38-07-070/001	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай /Тээвэр зууч/	Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2016.08.24-ний өдрийн 038/07/070/001 дугаартай удирдамжийн дагуу төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх аж ахуй нэгж, байгууллагад төмөр замын салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн дарга С.Дорждагва ахалж, төмөр замын тээврийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, улсын байцаагч Б.Батхүү, мэргэжилтэн, улсын байцаагч М.Энхболд, Х.Итгэлт, мэргэжилтэн Г.Даваадолгор, ТЗДТБХЗГ-ын мэргэжилтэн Б.Идэр, Б.Хулан нарын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтыг 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын үр дүнг ЗТХ-ийн Сайд, Дэд сайд, ТНБД нарт танилцуулсан ба “Цаашид авах арга хэмжээний санал”-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралд оруулж, 2017 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр шийдвэр гаргуулсан. Шийдвэрийн дагуу дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд: 1. Сайдын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу их, дунд эрсдэлтэй буюу зөрчил илэрсэн нийт 79 компани /Хавсралт 2/-д албан шаардлага хүргүүлсэн. Эдгээр компаниудаас 58 компани /Хавсралт 3/ 2017 оны 3

				<p>дугаар сарын 10-ны өдрийн дотор албан шаардлагын хариу ирүүлсэн.</p> <p>Мөн 17 компани /Хавсралт 4/ албан шаардлагын хариу ирүүлээгүй, 4 компани /Хавсралт 5/ албан шаардлагыг ирж аваагүй, 2016 оны 09, 10 дугаар сард шалгалтад хамрагдах үеийн утасны дугаар холбогдохгүй, ажлын байр дээр байгаагүй болно.</p> <p>2. Сайдын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу тодорхой шалтгааны улмаас шалгалтад хамрагдаагүй 57 компани, шалгалтаас зайлсхийсэн 25 компани буюу нийт 82 компанийг Зам, тээврийн хөгжлийн яаманд ирж, хяналт шалгалтад хамрагдах тухай олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан. Зарласан компаниудаас хяналт шалгалтад хамрагдсан 29 компани /Хавсралт 6/ байх ба 53 компани /Хавсралт 7/ ирж хяналт шалгалтад хамрагдаагүй болно.</p>
22.	2016.09.01	38-07-068/02	Салбар төмөр замын ачилт, буулгалтын талбайн барилгын ажлыг шалгах тухай /Материал импекс ХК, УБТЗ ХНН-ийн УБ өртөө	ТНБД-ын 2016.09.01-ний өдрийн 038/07/068/02 дугаар удирдамжаар “УБТЗ” ХНН-ийн Улаанбаатар өртөөнд “Материал импекс” ХХК-ийн ирүүлсэн хүсэлтийн дагуу салбар төмөр замын ачилт буулгалтын өндөрлөсөн тавцангийн барилгын ажлыг зураг төслийн дагуу хийгдсэн эсэхийг шалгаж стандарт дүрэм журамд нийцсэн талаар 16/09/11 дугаар дүгнэлт гаргасан.
23.	2016.09.16	38-07-068/04	Салбар төмөр замын барилгын ажлыг шалгах тухай /Сод Монгол групп ХХК, УБТЗ ХНН-ийн Баянтүмэн өртөө/	ТНБД-ын 2016.09.18-ны өдрийн 038/07/068/04 дугаар удирдамжаар “УБТЗ” ХНН-ийн Баянтүмэн өртөөнд “Сод Монгол” ХХК-ийн бариулсан салбар төмөр замыг батлагдсан зураг төслийн дагуу баригдсан эсэхийг шалгаж хамтарсан 16/04/12 дугаар дүгнэлт гаргасан.
24.	2016.10.13	38-07-070/08	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай /Монцемент билдинг материалс ХХК/	Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 38-07-070/08 дугаартай удирдамжийн дагуу “Монцемент билдинг материалс” ХХК-ийн оруулж ирсэн Украин улсын Крюковын Вагон заводод үйлдвэрлэгдсэн 19-7075 загварын 40 ш хоппер-вагоныг

				<p>Сэлэнгэ аймгийн Сүхбаатар өртөөний 8 дугаар зам дээр ажлын хэсэг 2016 оны 10 дугаар сарын 17-ноос 10 дугаар сарын 18-ны хооронд</p> <p>2 өдөр техникийн иж бүрэн үзлэг, шалгалт хийж хүлээн авсан. Хяналт шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Зам, тээврийн хөгжлийн яамны Зам, тээврийн хяналтын хэлтсийн төмөр замын тээврийн хяналтын мэргэжилтэн, Улсын байцаагч М.Энхболд ахалж, “УБТЗ” ХНН-ийн Вагоны аж ахуйн албаны орлогч дарга Ш.Гантулга, “УБТЗ” ХНН-ийн Ашиглалтын вагоны депо /ВЧД-3/-ийн Сүхбаатар өртөөн дэх Вагон техник үзлэгийн газар /ТҮГ/-ын дарга Б.Баярцэцэг, “Монцемент билдинг материалс” ХХК-ийн Борлуулалт хариуцсан мэргэжилтэн Л.Болдбаяр, тус компаний төмөр замын хэсгийн ахлах мэргэжилтэн Г.Гэрэлээ нар ажилласан. Шалгалтаар 40 ш хоппер вагон нь техникийн гэмтэлгүй, хэвийн ажиллагаатай байлаа. Украин Улсын Крюковын Вагон заводод үйлдвэрлэгдсэн 19-7075 загварын 40 ш хоппер-вагоны техникийн байдал нь “Төмөр замын тээврийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.4.5, 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, Монгол Улсын стандарт MNS 6276:2011 “Төмөр замын ачааны вагон. Техникийн ерөнхий шаардлага”, “Вагон ашиглалтын технологи” журмын шаардлагыг тус тус хангаж байгаа бөгөөд төмөр замын тээвэрт “ТЭНЦЭНЭ” гэж ажлын хэсэг дүгнэсэн. Ажлын хэсгийн техникийн актын дагуу “Монцемент билдинг материалс” ХХК-ийн ачааны вагонд 2016.05.20-ны өдрийн 038/07/070/10 дугаартай Улсын байцаагчийн дүгнэлт гаргаж өгсөн.</p>
25.	2016.10.17	38-07-068/09	Салбар төмөр замын барилгын ажлыг шалгах тухай/Мөнх ариун ундарга ХХК, УБТЗ ХНН-ийн Толгойт өртөө	ТНБД-ын 2016.10.17-ны өдрийн 038/07/068/09 дугаар удирдамжаар “УБТЗ” ХНН-ийн Толгойт өртөөнд “Мөнх ариун ундарга” ХХК-ийн ирүүлсэн хүсэлтийн дагуу салбар төмөр замын барилгын ажлыг зураг төслийн дагуу хийгдсэн эсэхийг шалгаж стандарт дүрэм журамд нийцсэн талаар хамтарсан 16/09/08 дугаар дүгнэлт гаргасан.
26.	2016.11.07	38-07-074/11	Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай/Сэлэнгэ, Болд төмөр ерөө гол ХХК,	ХШҮДАГ-ын даргын 2016.11.14-ний өдрийн 038/07/074/011 дугаар хяналт шалгалтын удирдамжийн дагуу Болд төмөр

			МТЗ ТӨХК-ийн төмөртэй өртөө/	ерөө гол ХХК, Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК-ийн тээврийн үйл ажиллагааг хийж буй МТЗ ТӨХК нь төмөр замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаад шалгалт хийж холбогдох дүгнэлт, зөвлөн туслах ажлын хүрээнд хамтарсан дугаартай зөвлөмж гаргаж өгч, тээврийн операторын үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 2017 онд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн.
27.	2016.11.14	38-07-074/12	Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх тухай /МТЗ ТӨХК/	ХШҮДАГ-ын даргын 2016.11.14-ний өдрийн 038/07/074/012 дугаар хяналт шалгалтын удирдамжийн дагуу МТЗ ТӨХК нь төмөр замын тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаад шалгалт хийж холбогдох дүгнэлт, зөвлөн туслах ажлын хүрээнд хамтарсан 038/07/074/01 дугаартай зөвлөмж гаргаж өгч, тээврийн операторын үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажиллаж байна. 2017 онд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн.
28.	2016.12.01	38-07-077/15	Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай /УБТЗ ХНН/	ХШҮДАГ-ын даргын баталсан 2016.12.01-ны өдрийн 038/07/077/15 дугаартай удирдамжийн дагуу “УБТЗ” ХНН-ийн гол замд байрлах гарам, гармын байгууламж, түүнд засвар үйлчилгээ хийж байгаа байдалд хамтарсан хяналт шалгалт хийсэн.
29.	2016.12.08	38-07-068/16	Салбар төмөр замын барилгын ажлыг шалгах тухай /Увт инвест ХХК/	ТНБД-ын 2016.12.16-ны өдрийн 038/07/068/16 дугаар удирдамжаар “УБТЗ” ХНН-ийн Толгойт өртөөнд “Мөнх ариун ундарга” ХХК-ийн ирүүлсэн хүсэлтийн дагуу салбар төмөр замын барилгын ажлыг зураг төслийн дагуу хийгдсэн эсэхийг шалгаж стандарт дүрэм журамд нийцсэн талаар хамтарсан 16/16/09 дугаар дүгнэлт гаргасан.